

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/103/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 135

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Анхан шатны баримтгүй томилолт олгосон, бараа материалын тооллого хийгээгүй, ажичлдад олгосон цалинг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй, шилэн дансны мэдээлэл хангалтгүй, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг материаллаг 127.1 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нугийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020253

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,958,507.50	113,928,738.50
35	БАРАА МАТЕРИАЛ	110,958,507.50	113,928,738.50
35100	Түүхий эд материал	93,669,110.50	93,999,565.50
35110	Тусгай зориулалттай материал	93,669,110.50	93,669,110.50
35130	Эм боох материал	-	330,455.00
35400	Хангамжийн материал	17,289,397.00	19,929,173.00
35410	Бичиг хэргийн материал	-	178,200.00
35420	Аж ахуйн материал	4,747,100.00	7,983,100.00
35440	Түлш, шатах тослох материал	5,255,300.00	2,262,500.00
35460	Хүнсний материал	362,625.00	2,581,001.00
35470	Бусад хангамжийн материал	6,924,372.00	6,924,372.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,013,246,560.31	988,512,317.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,013,246,560.31	988,512,317.48
39200	Биет хөрөнгө	978,306,560.31	953,572,317.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,006,325,042.95	1,006,325,042.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(194,306,831.07)	(224,031,258.81)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	141,922,911.74	143,302,911.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(105,505,889.28)	(108,476,369.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,685,638.67	110,905,638.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,150,927.50)	(48,657,512.84)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	57,672,000.00	57,672,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,655,000.00	3,655,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,460,250.00)	(1,593,000.00)
39217	Ном	14,469,864.80	14,469,864.80
39300	Биет бус хөрөнгө	34,940,000.00	34,940,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,940,000.00	34,940,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,124,205,067.81	1,102,441,055.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,871,694.86	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,871,694.86	-
41300	Өглөг	6,871,694.86	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,871,694.86	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,117,333,372.95	1,102,441,055.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,117,333,372.95	1,102,441,055.98
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	335,592,682.00	335,592,682.00
51200	Хуримтлагдсан үр дүн	133,564,455.43	118,672,138.46
51210	Өмнөх үеийн үр дүн	121,850,758.67	133,564,455.43
51220	Тайлант үеийн үр дүн	11,713,696.76	(14,892,316.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,176,235.52	648,176,235.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,124,205,067.81	1,102,441,055.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,109,513,755.91	991,418,348.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,383,273.91	991,418,348.00
120	Нийтлэг татварын бус орлого	97,383,273.91	14,974,819.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,383,273.91	14,974,819.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	97,383,273.91	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	11,220,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	3,754,819.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,012,130,482.00	976,443,529.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	879,242,800.00	863,208,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	879,242,800.00	863,208,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,747,082.00	6,771,029.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,747,082.00	4,548,729.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,222,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,140,600.00	106,464,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,140,600.00	106,464,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,097,686,725.73	1,006,310,664.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,097,686,725.73	1,006,310,664.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	993,709,193.87	991,208,953.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,689,985.42	690,772,096.00
210101	Үндсэн цалин	668,689,985.42	630,216,338.00
210104	Урамшуулал	-	46,131,606.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	14,424,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,106,706.71	87,032,791.37
210201	Тэтгэврийн даатгал	67,258,785.58	65,057,843.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,781,392.31	4,349,672.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,433,725.29	5,594,272.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,203,912.11	1,295,297.96
210205	Эрүүл мэндийн даатгал	13,428,891.42	10,735,705.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,003,712.87	110,776,350.47
210301	Гэрэл, цахилгаан	2,761,827.87	3,404,175.83
210302	Түлш, халаалт	97,344,700.00	106,169,074.64
210303	Цэвэр, бохир ус	897,185.00	1,203,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,008,940.00	11,739,879.00
210401	Бичиг хэрэг	2,196,640.00	1,896,029.00
210402	Тээвэр, шатахуун	9,040,450.00	3,812,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	1,747,800.00
210404	Ном, хэвлэл	2,452,150.00	2,222,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,000.00	451,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,319,700.00	1,610,000.00
210408	Бараа материал акталсны зардал	7,980,000.00	-

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	22,982,625.00	49,907,644.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,000.00	1,718,764.00
210502	Хоол, хүнс	22,611,625.00	48,023,880.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	165,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,610,000.00	245,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	110,000.00	145,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	220,000.00
210702	Дотоод албан томилолт	-	220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	269,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,000.00	269,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,511,223.87	40,245,492.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,597,900.00	2,911,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,913,323.87	37,334,242.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,977,531.86	15,101,711.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,812,432.00	11,396,584.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,251,200.00	6,101,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,991,232.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,570,000.00	5,295,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,691,677.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,691,677.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,283,037.13	13,449.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,283,037.13	13,449.55
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,882,062.73	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,882,062.73	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,827,030.18	(14,892,316.97)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	113,333.42	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	113,333.42	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,713,696.76	(14,892,316.97)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,013,130,482.00	976,443,529.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,130,482.00	976,443,529.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	879,242,800.00	863,208,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	879,242,800.00	863,208,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,747,082.00	6,771,029.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,747,082.00	4,548,729.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,222,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,140,600.00	106,464,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,140,600.00	106,464,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,006,130,482.00	975,063,529.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,006,130,482.00	975,063,529.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	902,152,950.14	942,746,311.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,888,205.56	696,274,617.59
210101	Үндсэн цалин	584,583,514.27	635,718,859.59
210104	Урамшуулал	64,067,645.00	46,131,606.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,237,046.29	14,424,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,106,706.71	88,401,964.66
210201	Тэтгэврийн даатгал	67,258,785.58	65,057,843.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,781,392.31	4,349,672.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,433,725.29	5,594,272.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,203,912.11	1,295,297.96
210205	Эрүүл мэндийн даатгал	13,428,891.42	12,104,878.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,674,062.87	106,351,050.45
210301	Гэрэл, цахилгаан	2,761,827.87	3,404,175.81
210302	Түлш, халаалт	101,628,800.00	101,743,774.64
210303	Цэвэр, бохир ус	1,283,435.00	1,203,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,840,990.00	11,829,979.00
210401	Бичиг хэрэг	1,476,040.00	1,740,529.00
210402	Тээвэр, шатахуун	9,098,200.00	4,079,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	1,485,000.00
210404	Ном, хэвлэл	2,452,150.00	2,222,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,000.00	491,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,544,600.00	1,811,000.00
2105	Нормативт зардал	16,187,085.00	35,793,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	365,000.00	1,570,000.00
210502	Хоол, хүнс	15,552,085.00	34,003,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	270,000.00	220,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,443,500.00	330,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	260,000.00	230,000.00
210604	Урсгал засвар	7,183,500.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	220,000.00
210702	Дотоод албан томилолт	-	220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	282,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	282,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,216,400.00	3,262,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,216,400.00	3,262,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,977,531.86	32,317,217.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,812,432.00	28,612,090.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,251,200.00	23,317,090.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,991,232.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,570,000.00	5,295,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,691,677.75
213302	Хаагдсан данс	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,691,677.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,283,037.13	13,449.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,283,037.13	13,449.55
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,882,062.73	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,882,062.73	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,000,000.00	1,380,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,000,000.00	1,380,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000,000.00	1,380,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,000,000.00	1,380,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,000,000.00)	(1,380,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	121,850,758.67	1,105,619,676.19
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	121,850,758.67	1,105,619,676.19
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	11,713,696.76	11,713,696.76
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	133,564,455.43	1,117,333,372.95
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	133,564,455.43	1,117,333,372.95
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	133,564,455.43	1,117,333,372.95
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,892,316.97)	(14,892,316.97)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	118,672,138.46	1,102,441,055.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	969,672,500.00	965,967,372.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,672,500.00	965,967,372.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	940,709,400.00	937,355,282.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,012,300.00	696,274,617.59
210101	Үндсэн цалин	636,371,500.00	635,718,859.59
210104	Урамшуулал	48,215,800.00	46,131,606.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,425,000.00	14,424,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,546,100.00	88,401,964.66
210201	Тэтгэврийн даатгал	62,521,000.00	65,057,843.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,405,000.00	4,349,672.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,304,000.00	5,594,272.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,304,100.00	1,295,297.96
210205	Эрүүл мэндийн даатгал	13,012,000.00	12,104,878.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,364,500.00	106,351,050.45
210301	Гэрэл, цахилгаан	3,410,000.00	3,404,175.81
210302	Түлш, халаалт	101,744,500.00	101,743,774.64
210303	Цэвэр, бохир ус	1,210,000.00	1,203,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,740,500.00	8,703,950.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,491,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,450,000.00	3,424,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,485,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	491,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,790,500.00	1,811,000.00
2105	Нормативт зардал	35,846,000.00	35,793,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,575,000.00	1,570,000.00
210502	Хоол, хүнс	34,051,000.00	34,003,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	220,000.00	220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	340,000.00	330,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	230,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	400,000.00	220,000.00
210702	Дотоод албан томилолт	400,000.00	220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	460,000.00	282,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	460,000.00	282,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	997,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	997,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,963,100.00	28,612,090.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,963,100.00	28,612,090.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,663,100.00	23,317,090.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,300,000.00	5,295,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	969,672,500.00	965,967,372.70
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	863,208,000.00	859,516,322.25
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	863,208,000.00	859,516,322.25
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,464,500.00	106,451,050.45
320001	Орон нутгийн төсвөөс	106,464,500.00	106,451,050.45

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,771,029.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,771,029.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,771,029.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,126,029.00
210401	Бичиг хэрэг	248,729.00
210402	Тээвэр, шатахуун	655,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-
210404	Ном, хэвлэл	2,222,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,380,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,265,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,265,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,771,029.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,771,029.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,548,729.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,222,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 12 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын код :ГАА-2022/103/-НА-СТА-ТШЗ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны зардлын 995.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 15.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлыг тайлант оны нийт зардлын 1,107.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцож шинэчлэн тогтоосон материаллаг байдал 22.1 сая төгрөг, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувь буюу 17.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.5 хувиар буюу 46.2 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Тайлант хугацаанд авлагагүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 113.9 сая төгрөг болж 3.0 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 75.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 76.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,369.8 сая төгрөг болж 11.2 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогтой холбоотой. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 11.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант хугацааны элэгдэл 37.3 сая төгрөгөөр нэмэгджээ.

Тайлант оны эцэст өглөггүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,102.4 сая төгрөг болж 14.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орлого өмнөх оноос 8.9 хувиар буюу 117.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 133.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,112.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 143.2 сая төгрөгөөр бууруулж, 969.7 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь цалингийн зардал, тогтмол зардал, томилолт зочны зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 969.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 863.2 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 106.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 965.9 сая төгрөгийг зарцуулж 3.7 сая төгрөгийг улсын төсөвт, 0.01 төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 965.9 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 2.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлаас 0.2 сая төгрөг, норматив зардлаас 0.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.3 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллаас 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 6.7 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 4.5 сая төгрөг дээд шатны байгууллагаас төслийн санхүүжилт, 2.2 сая төгрөгийг сурах бичгийн түрээсийн орлогоос олсон байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 3.3 сая төгрөгийн хангамж бараа материалын зардалд, 1.4 сая төгрөгийн зардлыг багаж техник хэрэгсэл худалдан авах зардалд, 2.0 сая төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 606.9 сая төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулахаас сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 534.4 сая төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлээгүй байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 75.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг биелүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Шилэн дансны мэдээллийн тоон үзүүлэлт
- Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн байдал
- Хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 129.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.5 сая төгрөгийн алдаа залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 126.95 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл зөрүүтэй, зардал хооронд гүйлгэн бүртгэсэн 0.5 сая төгрөг, бараа материалын тайланд няравын тайлан болон хөндлөнгийн тулгалтаас зөрүүтэй тайлагнасан 0.4 сая төгрөгийн, санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлангаас 1.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчлийг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Томилолтын хуудасгүй, илтгэх хуудасгүй 0.2 сая төгрөгийн томилолт олгосон нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдэгдлийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 8.2 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Ажилчдад олгосон цалингаас нийгмийн даатгалын тайланг 4.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх үүрэгтэй" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Бараа материалын тооллогын үлдэгдэл НББ-ийн үлдэгдлээс 113.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 0.05 сая төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага",

заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Шилэн дансанд мэдээлэх 143 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.Хугацаандаа мэдээлсэн 137 мэдээлэлд тоон үзүүлэлтийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль	10	129.6	3	2.5	1	0.2	6	126.9	-	-
	ДҮН	10	129.6	3	2.5	1	0.2	6	126.9	-	-